



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2008 оны 5 дугаар сар

Үйлдвэрлэгчийн давхар тарифыг Эрчим хүчний зохицуулах газар хэрэгжүүлж эхэллээ

Эрчим хүчний зохицуулах газар (ЭХЗГ) хоёр жилийн туршид хийсэн нарийвчилсан судалгаа, бэлтгэл ажлаа дүгнэн 5 дугаар сарын 1-ээс эхлэн үйлдвэрлэгчийн цахилгааны давхар тариф (буюу чадал энергийн тариф)-ыг хэрэгжүүлэх болсон тухай зарлалаа. Давхар тарифаар үйлдвэрлэгчээс дамжуулах сүлжээнд түгээсэн цахилгааны төлбөрийг тооцно. Үйлдвэрлэсэн цахилгаан нь дамжуулах сүлжээнээс цааш түгээхээр дамжин хэрэглэгчдэд очдог.

Давхар тариф нь нэгдсэн тарифаас дараах давуу талтай. Үүнд:

- Эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалтыг



нэвтрүүлснээр агаарын бохирдлыг багасгаж, хэрэглэгчдийн цахилгааны төлбөрийг бууруулна.

- Үйлдвэрлэгчийн үр өгөөжийг цаашид нэмэгдүүлж, цаашид агаарын бохирдлыг багасгаж, хэрэглэгчдийн цахилгааны төлбөрийг бууруулах нөлөө үзүүлнэ.
- Эрчим хүчний найдвартай хангалтыг бататгаж, хэрэглэгчийн цахилгааны тасалдалын тоог бууруулна.

Эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалт

Эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалт гэж хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг аль болох өргөнөөр хангахад хамгийн бага зардалтай үйлдвэрлэгчийг түрүүлж ачааллан, ачаалал нэмэгдэх тусам илүү өндөр өртөгтэй үйлдвэрлэгчийг ачааллах үйл ажиллагааг хэлнэ.¹ Тодруулбал, эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалт гэж цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах байгууламжийн үйл ажиллагааны хязгаарлах хүчин зүйлүүдийг харгалзан,

¹ Үүнийг дараах эх үүсвэрээс иш татсан болно: Эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалтын үнэ цэнэ (*The Value of Economic Dispatch*), A report to Congress Pursuant to Section 1234 of the Energy Policy Act of 2005, prepared by United States Department of Energy, November 7, 2005 (see website:

<http://www.oe.energy.gov/DocumentsandMedia/value.pdf> .

Энэхүү цувралд нийтлэгдсэн санаа бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг заавал илэрхийлсэн байх албагүй болно.

хэрэглэгчдэд илүү найдвартай үйлчилгээг хамгийн бага зардлаар үзүүлэхийг хэлнэ.

Энэхүү зохицуулалт нь цахилгааны хэрэглэгчдэд хэд хэдэн талын ач холбогдолтой. Эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалт нь цахилгааны эрэлтийг хамгийн бага өртөгтэй эрчим хүчний үйлдвэрлэлээр хангах замаар цахилгааны нийт зардлыг бууруулдаг. Зардлыг багасгахын тулд диспетчерийн энэхүү зохицуулалт нь үр ашигтай үйлдвэрлэгчийг илүү ачааллаж, түүний ашиглалтыг сайжруулж, түлшний хэрэглээг бууруулж, улмаар агаарын бохирдолыг багасгана. Агаарын бохирдол багасах, цахилгааны төлбөр буурах зэргээр энэхүү өгөөжийг хэрэглэгчдэд дамжуулан хүртээнэ.

Давхар тариф

Сайтар боловсруулсан давхар тарифын загвар нь Диспетчерийн үндэсний төв (ДҮТ)-өөс үйлдвэрлэгч компаниудад орлогоороо зардлаа нөхөх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хамгийн бага зардалд (өөрөөр хэлбэл эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалтад үндэслэн) үндэслэн үйлдвэрлэгч компаниудад диспетчерийн зохицуулалт хийх нөхцлийг бүрдүүлнэ.

Үүнээс гадна энэхүү тариф нь үйлдвэрлэгч эрсдэлийг компани, хэрэглэгчдийн хооронд илүү шударга байдлаар хуваарилахын зэрэгцээ тэдгээр компаниудын үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болно. Энэхүү тариф нь үйл ажиллагаагаа сайжруулж чадсан компаниудын орлогыг нэмэгдүүлэн урамшуулах, эсрэг тохиолдолд орлогыг бууруулан хариуцлага тооцох боломжийг бүрдүүлэх юм.

Энэхүү давхар тариф нь үйлдвэрлэгч компаниудыг энерги үйлдвэрлэх болон найдвартай байдлаа хангах гэсэн хоёр үйлчилгээ үзүүлэхийг шаарддаг. Энерги гэж хэрэгцээт бүтээгдэхүүнээр (цахилгаан энергиэр) хангахыг хэлж байгаа бол найдвартай байдал гэж цахилгаан тасалдалгүй үйлдвэрлэх боломжийг хэлнэ. Өөрөөр хэлбэл ДҮТ-өөс даалгавар өгөхөд энерги үйлдвэрлэх боломжтой байна гэсэн үг. Иймд давхар тариф дараах хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг. Үүнд:

- 1) Үйлдвэрлэгчийн энерги үйлдвэрлэх буюу хувьсах зардлыг нөхөх энергийн тариф
- 2) Энергийн тарифт багтаагүй үйлдвэрлэгчийн тогтмол бүх зардлыг нөхөх чадлын тариф

Үйлдвэрлэгчийн энерги үйлдвэрлэх зардалд үйлдвэрлэлийн хэмжээтэй уялдан хувьсан өөрчлөгддөг бүх зардал, ялангуяа үндсэн түлшний зардал (Монголын хувьд нүүрс), тослох материал, үнсэн сан гэх мэт ашиглалтын болон засвар үйлчилгээний хувьсах зардал багтана. Давхар тарифыг нэвтрүүлснээр үйлдвэрлэгчид хичнээн хэмжээний энерги үйлдвэрлэх нь ялгаагүй болдог учир ДҮТ-өөс үйлдвэрлэгчийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнээс үл хамааран эдийн засгийн үндэслэлтэй диспетчерийн зохицуулалтыг чөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой болно. Хэрэв үйлдвэрлэгч төлөвлөснөөсөө илүү үйлдвэрлэвэл орлого болон зардал нь адил харьцаагаар өснө. Үүний нэгэн адил хэрэв үйлдвэрлэгчид төлөвлөснөөсөө бага үйлдвэрлэвэл орлого болон зардал ижил харьцаагаар буурна.

Давхар тарифын загвар нь бэнчмаркингийг ашиглаж, станцын гүйцэтгэл бүтээмжийг сайжруулж, бүх зардлаа хэрэглэгчдэд шууд шилжүүлдэг байдлыг хална. Бэнчмаркингийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл (магадгүй сүүлийн гурван жилийн дунджаар) болон гадаад, дотоодын ижил үйлдвэрлэгчийн гүйцэтгэлд тулгуурлан гаргана. Ингэснээр хэрэв

үйлдвэрлэгчийн гүйцэтгэл нь бэнчмаркингаас дээш байвал компани ашгаа нэмэгдүүлэх бөгөөд эсрэг тохиолдолд орлогын бууралтыг хэрэглэгчдэд шилжүүлэх бус компани өөрөө хариуцах болно. Энэ нь үйлдвэрлэгчийн гүйцэтгэл сайн байх тусам ашиг өндөр байна гэсэн өрсөлдөөнт зах зээлийн зарчимд нийцэж байгаа билээ.

Жуумла! Монгол хэлнээ боловсруулсан хувилбарын талаар сургалт-семинар боллоо

5-р сарын 20-ны өдөр Мэдээлэл технологийн үндэсний паркард Жуумла! Монгол Агуулгын Удирдлагын Системийн (АУС) талаар нэг өдрийн практик сургалт-семинар болж, төрийн байгууллагуудын 29 вэбмастер оролцов.

Төслийн зүгээс 2007 оны 6-р сард Жуумла! Монгол АУС-ийн бэта туршилтын хувилбарыг боловсруулж, олон нийтэд түгээж эхэлсэн юм. Төсөл нь мөн хугацаанд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газартай (МХХТГ) хамтран Жуумла! Интернэйшл шийдлийн орчуулсан хувилбар болох (монгол хэлнээ бүрэн хөрвүүлсэн) Жуумла! Монгол АУС-ийг боловсрууллаа. Төсөл нь олон нийтийн дэмжлэгтэйгээр зургаан сарын турш эрчимтэй шалган туршиж, программын алдааг засварласны дараа түүний олон нийтэд нээлттэй эх лиценз ОННЛ-ийн хүрээнд 2007 оны 12-р сард Жуумла! Монгол 1.0 гэсэн хувилбарыг албан ёсоор гаргахад МХХТГ-т туслалцаа үзүүлсэн юм. Жуумла! 1.0.15 шинэчилсэн хувилбарыг оруулахын тулд 2008 оны 3-р сард Жуумла! Монгол 1.1 хувилбарыг боловсруулан гаргалаа.

Жуумла! Интернэйшл болон Монгол хувилбарыг олон нийтэд зориулж мэдээллийн вэбсайт ажиллуулдаг Монгол улсын төрийн байгууллагуудын англи хэлний мэдлэг, төсвийн хүндрэлтэй байдлыг шийдвэрлэхийн тулд боловсруулсан юм. Жуумла! Монгол агуулгын удирдлагын системийг анхлан Үндэсний Татварын ерөнхий газрын (ҮТЕГ) вэбсайтад зориулж боловсруулсан боловч үүнийг төрийн байгууллагуудын болон бусад вэбсайтуудад өргөнөөр ашиглах боломжтой болсон юм. Одоогоор Монгол улсын 1,360 вэбсайтад Жуумла! Монгол хувилбарыг ашиглаж ажиллуулж байна.



Жуумла! Монгол АУС-ийг ашиглаж буй Монгол улсын вэбсайтууд

5-р сарын эцсийн байдлаар Жуумла! Монгол хувилбарыг ашиглаж буй вэбсайтуудад дараахь орж байна:

- МУЗГ-ын яамд, агентлагуудын 48 идэвхтэй вэбсайт
- Эдгээрийн 8-ыг нь төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан
- Дээрх вэбсайтуудыг оруулаад нийт 1,360 вэбсайт.


ҮТЕГ болон Засгийн газрын нээлттэй вэбсайтыг Жуумла! Монгол хувилбарыг ашиглан шинэчилсэн. Түүнчлэн Гадаад хэргийн яам нь Жуумла! Монгол хувилбарын хэрэгслүүдээр вэбсайтаа шинэчиллээ.

Жуумла! Интернэйшл АУС-ийг ашиглаж буй вэбсайтуудад дараахь орж байна. Үүнд:

- Нийт 6,550 вэбсайт
- 12 улсын "эх хэлэнд орчуулсан" буюу хөрвүүлсэн. Үүнд:

2008.05.19-ны өдрийн байдлаар, мэдүүлжээ	
Арт (онд)	899
Монго (онд)	18.9
Зас (онд)	8.342
Цахр (онд)	2.351
Цахын туслах (онд)	25.22
Хэрэглэгч (онд)	3.215
Ганц болон (онд)	39.683
Хувийн цахив (онд)	3.029
Нөхцөл (онд)	26.405

- Монгол (Албан ёсны вэбсайт – www.joomla.gov.mn)
- Тайланд (www.joomlacorner.com)
- Вьетнам (www.joomlavietnam.org)
- Босни (www.bhoomla.com)
- Чех (www.joomlaportal.cz)
- Словак (www.joomla.sk)
- Унгар (www.joomla.org.hu)
- Польш (www.joomla.pl)
- Франц (www.joomlafrance.org)
- Герман (www.joomla.de)
- Өмнөд Африк (www.joomla.org.za)
- Испани (www.joomlaspanish.org)



Жуулчны шинэ маршрутыг онцлох Монгол улсын аяллын хөтөч, лавлагааны Одиссейн цуврал

Монгол улсын аяллын хөтөч, лавлагаа болох 600 хуудас бүхий Одиссейн цувралын ерөнхий редактор, зохиолч Карл Робинсон болон ЭЗБШӨЧ төслийн баг нь Монгол улсын талаар урьд өмнө гарсан аяллын хөтөч, лавлагааны бусад ном, хэвлэлд дэлгэрэнгүйгээр ороогүй байсан онгон байгаль, хүний гараар бүтсэн соёлын өв, түүхэн дурсгалт газруудыг судлах зорилгоор 5-р сарын 27-ноос 6-р сарын 3-ны өдрүүдэд Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь аймгуудаар аялсан.

Аяллын хугацаанд дээрх багаас Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт эртний хүмүүсийн амьдарч байсан Цагаан Агуй, хүрэл зэвсгийн үед хамаарах нэг дор олноор байдаг хадны сүг зураг бүхий Бичигтийн хадыг үлэг гүрвэлийн чулуужсан ясны олдвороор баялаг Өмнөговь аймгийн Хэрмэн цавтай холбох аяллын шинэ маршрутыг нээлээ.

Энэхүү маршрутаар энэ бүс нутгийг сайн мэдэх цөөн тооны тур операторууд л жуулчин гийчдийг хүлээн авч байна. Төв, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь аймгуудыг хамарсан 2,600 км энэ маршрутыг сурталчилснаар Баянхонгор аймгийг аяллын шинэ бүс нутаг болгож улмаар 1923 онд Рой Чэпмэн Эндрюсийн нээж, газрын зураг дээр тэмдэглэсэн Баянзагт (Flaming Cliffs) аялах жуулчдын хөдөлгөөний ачааллыг багасгах болно.

Төслийн зүгээс Монгол улсын аяллын хөтөч, лавлагаа болох энэхүү шинэ номыг 2009 онд хэвлүүлэхээр төлөвлөж байгаа ба Одиссей



хэвлэлийн компанитай хамтран ажиллаж байгаа нь Монгол улсын аялал жуулчлалын шинэ маршрутыг сурталчлахын тулд хийж буй ажлынх нь нэг хэсэг болж байна.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал харуулсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.

